



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 05 дугаар сарын 03
№ 17 /926/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1253

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1255

Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн
тухай хуульд нэмэлт оруулах
тухай

Ирээдүйн тэтгэврийн
нөөц сангийн тухай хууль
батлагдсантай холбогдуулан
авах зарим арга хэмжээний
тухай

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

456. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 1253

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

457. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 36 1254

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

458. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай Дугаар 29 1255

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

459. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 137 1255

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсэг нэмсүгэй:

“17.4.Хуулиар шийдвэрлэх хугацааг тусгайлан заасан асуудлыг санаачилсан хууль санаачлагч болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.12-т заасан санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн уг асуудлыг хэлэлцэхэд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй, эсхүл төсөл, саналаа танилцуулаагүй бол тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, саналыг хууль санаачлагчид буцаасанд тооцно.”



2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэгт “Хуулиар шийдвэрлэх хугацааг тусгайлан заасан асуудлаар нам, эвслийн бүлэг завсарлага авах бол хуралдаан даргалагч тухайн асуудлыг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэхэд саад болохгүй байхаар завсарлагын хугацааг тогтооно.” гэсэн 3 дахь өгүүлбэр нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний аюулгүй байдлын тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 04 дүгээр
сарын 26-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Одонжилийг эгүүлэн татаж, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулууны Баярмөнхийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 3 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 137

Улаанбаатар
хот

Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Монголын Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Ипотекийн зээл, санхүүжилтийн ерөнхий журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн 2016 оны төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэн батлуулахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, Сангийн сайд Б.Болор нарт даалгасугай.



3. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн эх үүсвэрийг Монголбанкнаас Нийгмийн даатгалын санд шилжүүлэн авах, хуульд заасны дагуу сангийн хөрөнгийн удирдлагыг Монголбанкаар гүйцэтгүүлэх, үүнтэй холбоотой гэрээг Монголбанкт байгуулахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд даалгасгай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 97 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тогтоолыг Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

Засгийн газрын 2016 оны 137 дугаар
тогтоолын хавсралт

**ИПОТЕКИЙН ЗЭЭЛ, САНХҮҮЖИЛТИЙН
ЕРӨНХИЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль, Засгийн газар, Монголбанкны хамтран хэрэгжүүлж байгаа “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр” (цаашид “хөтөлбөр” гэх)-ийн хүрээнд Монгол Улсын иргэнд орон сууцны ипотекийн зээл олгох нөхцөл, санхүүжилтийн бүтцийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Дараах орон сууц худалдан авах иргэнд энэ журмын дагуу ипотекийн зээл олгоно:

1.2.1. төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга, холбоо дохиолол)-д бүрэн холбогдсон, эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтад хүлээн авсан, барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын шийдвэрээр ашиглахыг хориглоогүй, нийтийн зориулалттай дараах орон сууц:



а) Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүс¹, гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүс, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт баригдсан;

б) хөдөө, орон нутаг буюу 21 аймгийн нутаг дэвсгэрт баригдсан;

в) энэ журмын 1.2.1.а-д зааснаас бусад Улаанбаатар хотын дүүрэгт баригдсан.

1.2.2. Аймаг, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барьсан бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтад хүлээн авсан, барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын шийдвэрээр ашиглахыг хориглоогүй, дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга)-ийн шийдэл бүхий дараах амины орон сууц:

а) нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт баригдсан;

б) хөдөө, орон нутаг буюу 21 аймгийн нутаг дэвсгэрт баригдсан.

1.3. Энэ журмын дагуу олгох ипотекийн зээлийг Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, заавал байлгах нөөцийн шаардлагыг ханган ажиллаж байгаа, журмын 4.9-т заасан ерөнхий гэрээнд нэгдэн орсон банк (цаашид “оролцогч банк” гэх)-аар дамжуулан олгоно.

Хоёр. Зээлийн ерөнхий нөхцөл

2.1. Ипотекийн зээлийн хугацаа 30 хүртэл жил байна.

2.2. Ипотекийн зээлийн жилийн хүү болон зээлээр худалдан авах орон сууцны нийт талбайн хэмжээг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар тогтооно.

2.3. Ипотекийн зээлээр худалдан авах орон сууцны нийт талбайн хэмжээг “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал” MNS 6058:2009 стандартын дагуу тооцно.

2.4. Энэ журамд заасны дагуу ипотекийн зээлээр худалдан авах

¹ УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 4.4.3.7-д заасан шинэ суурьшлын бүс



орон сууцны урьдчилгаа төлбөрийн хэмжээ тухайн орон сууцны үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

2.5. Зорилтот бүлгийн иргэд энэ журмын 2.4-т заасан урьдчилгаа төлбөрийг төлөхөд Засгийн газраас хөнгөлөлт үзүүлж болно. Урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх хэлбэр, нөхцөл, хамрагдах шалгуурыг Засгийн газар батална.

2.6. Ипотекийн зээл хүсэгч өөрийн өмчлөлд байгаа сууцыг барьцаа болгон энэ журамд заасны дагуу ипотекийн зээл авч, шинээр худалдан авах орон сууцны урьдчилгаа төлбөрийг төлж болно.

2.7. Ипотекийн зээлийн барьцааны зүйл нь энэ журмын 2.6-д зааснаас бусад тохиолдолд тухайн зээлээр худалдан авах орон сууц байна.

2.8. Ипотекийн зээлийг холбогдох гэрээний хугацаа дуусахаас өмнө төлж болно.

2.9. Энэ журамд заасны дагуу олгох ипотекийн зээл нь бүрэн хорогдох, тогтмол хүүтэй байна.

Гурав. Ипотекийн зээлийн шалгуур үзүүлэлт

3.1. Ипотекийн зээл авах иргэн дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1. Монгол Улсын иргэн, 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай байх;

3.1.2. банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

3.1.3. шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, төлбөргүй байх;

3.1.4. зээлийн хугацаа дуустал холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгалд хамрагдах;

3.1.5. барьцаалбар үйлдсэн байх.

3.2. Ипотекийн зээлийн барьцааны зүйл болох орон сууц дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1. Монгол Улсад байршилтай, нийтийн зориулалттай болон амины орон сууц байх;

3.2.2. зээлийн хугацаа дуустал холбогдох хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгийн даатгалд хамрагдсан байх;

3.2.3. ашиглалтад зохих журмын дагуу бүрэн хүлээн авсан байх;

3.2.4. эд хөрөнгө өмчлөх болон бусад эрхийн талаар гуравдагч этгээдэд шаардах эрх үүссэн бол түүнийг хэлцлийн талууд зөвшөөрсөн байх;

3.2.5. биет байдал, чанарын доголдолгүй байх;

3.2.6. инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын шийдвэрээр ашиглахыг хориглоогүй байх;

3.2.7. амины орон сууцны хувьд газрыг өмчлөх, эзэмших эрх улсын бүртгэлд бүртгэгдсэн байх.

Дөрөв. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо

4.1. Засгийн газар Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу ирээдүйн тэтгэврийн нөөц сан (цаашид “сан” гэх)-г байгуулна. Сангийн хөрөнгийг ипотекийн зээлээр баталгаажсан бондоор гэрчлэгдэх эрх болон ипотекийн санхүүжилтийн гэрээгээр үүссэн шаардах эрхийг Монголбанкнаас шилжүүлэн авч бүрдүүлнэ.

4.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр сангийн төсвийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

4.3. Засгийн газар сангийн хөрөнгийн өмчлөх эрхийг хэрэгжүүлэх эрхийг гэрээгээр Монголбанкинд олгоно. Уг гэрээнд хөрөнгийн удирдлагатай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тусгана.

4.4. Монголбанк сангийн мөнгөн хөрөнгөөс орон сууцны ипотекийн санхүүжилтийг оролцогч банкинд олгох бөгөөд оролцогч банкны ипотекийн зээлийн үйл ажиллагааг Монголбанкнаас баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-аар зохицуулна.

4.5. Сангийн хөрөнгөөс оролцогч банкинд олгох ипотекийн санхүүжилтийн хүү, хугацаа, хэмжээ, санхүүжилтийн хуваарийг Монголбанк тогтооно.



4.6. Сангийн хөрөнгө болох ипотекийн зээлээр баталгаажсан бондын хүүгийн орлогоос орон сууцны урьдчилгаа төлбөрийн хөнгөлөлтийг санхүүжүүлж болох бөгөөд уг үйл ажиллагааг энэ журмын 2.5-д заасан журмаар зохицуулна.

4.7. Оролцогч банк сангийн хөрөнгөөс олгосон ипотекийн санхүүжилт болон санд худалдсан ипотекийн зээлээр баталгаажсан бондын эх үүсвэрээр ипотекийн зээл олгоно.

4.8. Оролцогч банк ипотекийн зээлийг “Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК (цаашид “МИК ОССК” ХХК гэх)-ийн үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компанид худалдах, тус компанийн гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бондыг худалдан авах талаар зохих журмын дагуу хэлцэл хийнэ.

4.9. Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтолцоонд оролцогч талуудын эрх, үүрэг, тэдгээрийн хооронд хийх санхүүгийн бүтээгдэхүүний хэлцлийн бүтэц, нөхцөлийг Засгийн газар, Монголбанк, оролцогч банкууд, “МИК ОССК” ХХК-ийн хооронд байгуулах Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд тусгана.

Тав. Бусад

5.1. Энэ журмын хэрэгжилтэд орон сууц болон санхүү, төсвийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

5.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0,5

Индекс: 14003